

БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2025 ОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 12 дугаар сарын 23

Өргөн

Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, дүрэм журмын шинэчлэлийн дагуу байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах ажлыг зохин байгуулан ажилласан. Байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ажлыг дотоод журамдаа тусган хэрэгжүүлсэн байна. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ийн шинэчлэлийн дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн зохион байгуулж журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Мөн төрийн албаны "ХНУМТ" цахим системд мэдээллийг үнэн зөв оруулах, мэдээллийн шинэчлэн ажилласан.

Тухайн шатны байгууллагад хамаарах сул орон тооны зарыг дээд шатны төрийн албаны зөвлөлд хүргүүлэн тухай бүр орон тоог Төрийн албаны зөвлөлийн сул орон тоог нөхөх зар дээр байршуулан ажилласан.

2025 оны жилийн эцсийн дүнгээр Хөдөө аж ахуйн тасагт Хөдөө аж ахуйн мэргэжилтэн, хүнс жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний орон тооны зарыг дээд шатны Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголтой холбогдуулан Засгийн газраас төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг оновчтой болгох ажлын хүрээнд багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Уг арга хэмжээний хүрээнд төрийн үйлчилгээний 4 орон тоог цомхотгосон.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_